



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.21 № 3/499
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасны дагуу “Мон-Атом” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Мон-Атом” ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

“Мон-Атом” ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудиторын хүлээх хариуцлага нь Аудитын олон улсын стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан санхүүгийн тайланд дүгнэлт өгөх явдал юм. Гэхдээ Татгалзсан дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан асуудлуудын улмаас бид аудитын дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй байсан.

Татгалзсан дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Дараах асуудлуудаас шалтгаалж олон тооны тодорхой бус байдал бүрт харгалзах аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авч чадаагүй бөгөөд уг тодорхой бус байдлуудын үр дагавар ба санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөг тодорхойлох боломжгүй байна.

- Нэмэгдсэн өртөгийн албан татварын илүү төлөлтийн 96,3 сая төгрөгийн авлага, Мон Зим Интернэшнл ХХК-д төлөх 109,000 ам доллар буюу 216,1 сая мянган төгрөгийн өр төлбөрийг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа нь,
- 2013 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээний дагуу “Ураниум индастри” ХК-аас авсан 2,000.0 доллар буюу 4,917.0 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр, 1,927.5 сая төгрөгийн эрэл хайгуул, тандан судалгааны ажлын төлбөрийг биет бус /хайгуул үнэлгээний/ хөрөнгө гэж бүртгэж тайлагнасан нь СТОУС-ын холбогдох шаардлагад нийцээгүй байх бөгөөд холбогдох баримт бичиг, шийдвэр дутуу байгаагаас дээрх дүнг залруулах, эсвэл данснаас хасахтай холбоотой санхүүгийн тайланд нөлөөлөх үр дагаварыг тооцох боломжгүй байгаа нь,

- 2015 онд зээлийн гэрээний дагуу "Ураниум индастри" ХК-аас валютаар авсан 150,000 ам доллар, бэлэн бусаар тооцсон 51,000 ам доллар, нийт 251,000 ам долларын зээлийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагыг толилуулж тодруулаагүй,
- "Мон-Чех Ураниум" хамтарсан компанид зээлийн эх үүсвэрээр оруулсан 51,000 ам долларыг хөрөнгө оруулалтаар бүртгээгүй,
- Санхүүгийн байдлын тайланд илэрхийлсэн "Төв азийн уран" ХХК оруулсан 755,928.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн байдлын тайланд бүртгэж толилуулаагүй "Мон-Чех Ураниум" ХХК-д оруулсан байвал зохих 51,000 ам доллар буюу 126,966.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт нь үнэн зөв толилуулагдсан эсэх, хамтран хянадаг дээрхи компанийн хөрөнгөөс тус компанийн эзэмших хувь хэмжээ бодитой эсэхийг нотлох хангалттай бөгөөд зохистой нотолгоо олдоогүй, өмнөх аудитаар энхүү асуудал илэрч аудиторын дүгнэлтийн хязгаарлалтын нөхцөл болсон бөгөөд бидний өгсөн зөвлөмжийн дагуу тус компанийн удирдлагаас хөрөнгө оруулалтыг баталгаажуулах талаар удирдлагаас хариу арга хэмжээ аваагүй өнөөг хүрсэн.
- Мөнгөн хөрөнгийг 0,6 сая төгрөгийн зөрүүтэйгээр санхүүгийн тайланд бүртгэж толилуулсан нь
- Анхан шатны барим болон дэмжих баримтын зөрчилтэй 49,3 сая төгрөгийн, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайланд тусгагдаагүй байх магадлалтай 15,8 сая төгрөгийн санхүүгийн баримт, цалин, НДШ, ХХОАТ тооцолт, тайлагналаас 12,4 сая төгрөгийн зөрчил гарсан нь,
- Тайлант онд орлого олоогүй, зорилтот түвшин, зардлын хязгаарыг баталж өгөөгүй байхад хандив, бэлэг, баяр ёслол тэмдэглэн өнгөрүүлэхэд 14,0 сая төгрөгийг зарцуулж, зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1-р зүйлд заасныг зөрчиж 2016 оны зорилтын саналаа батлуулаагүй байгаа нь
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртөгийн албан татварыг зохих ёсоор тайлагнаагүй нь,
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч холбогдох нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн журнал, тайлан, дэлгэрэнгүй бүртгэлийг зохих ёсоор бүрэн гүйцэд хөтлөөгүй нь

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", СТОУС 6 "Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ", СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.46 өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, 4.49 зардлын хүлээн зөвшөөрөлтийг тус тус зөрчиж, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Татгалзсан дүгнэлт

Татгалзсан дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлийн ач холбогдлоос шалтгаалан бид аудитын дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй бөгөөд алдаа зөрчил нь санхүүгийн тайланд тархмал бөгөөд өндөр дүнгээр нөлөөлөхөөр байсан. Иймээс, бид "Мон-Атом" ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122



“МОН-АТОМ” ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ҮАГ-ын САГ-ын дарга:

Ц.Наранчимэг

Утас: 261663

ҮАГ-ын аудитын менежер:

Я.Самбууням

Утас: 263755

ҮАГ-ын шинжээч:

Б.Баярмаа

Утас: 261885

Монгол Улсын Үндэсний Аудитын

газар

Засгийн газрын IY байр

Улаанбаатар-46

Бага тойруу 6

Цахим хуудас: www.audit.mn

Од бүртгэл Аудит ХХК

Захирал: У.Оюунаа

Утас: 99051826

Ахлах аудитор: С.Бумацэцэг

Утас: 88067851

Аудитор Г.Нямгэрэл

Утас: 99941282

Аудиторын туслах: Ө.Золжаргал

Утас: 99886809

Сүхбаатар дүүрэг 1 хороо,

Олимпийн гудамж, Цэлмэг

тауэрийн 701 тоот

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллагийн түвшин
6. Дотоод хяналт
7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мон-Атом ХХК-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-САГ/2017/4/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Мон-Атом” ХХК-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ болон нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдах албан тушаалтан санхүүгийн тайлангаа СТОУС, НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Мон-Атом” ХХК-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 27-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Од бүртгэл Аудит ХХК-ийн С.Буманцэцэг ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Мон-Атом” ХХК нь 2016 оны IV улирлын санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 23-нд Од бүртгэл Аудит ХХК-д ирүүлсэн байна.

“Од бүртгэл Аудит” ХХК нь жилийн эцсийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 27-нээс 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд Үндэсний Аудитын Газрын Санхүүгийн аудитын газраар хянуулж, “Мон-Атом” ХХК-д хуулийн хугацаанд гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Мон-Атом” ХХК-ын удирдлага нь Монгол улсын “Компанийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Цөмийн энергийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

“Мон-Атом” ХХК нь 2009 онд Монгол улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор 100% Төрийн өмчит компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд гүйцэтгэх захирлаар Э.Галбадрал, нягтлан бодогчоор Л.Батзориг нар ажиллаж байсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 68 дугаар тогтоолоор “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувийг 100 хувь “Эрдэнэс Монгол” ХХК руу шилжүүлсэн боловч дээрх тогтоол нь 2016 оны 8 дугаар сарын 17-ны 35 дугаар тогтоолоор хүчингүй болсон. “Мон-Атом” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 07 тоот тогтоолын дагуу Л.Ганбаатарыг 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэж байсан. 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс ерөнхий нягтлан бодогчоор Н.Цэгмид ажиллаж байна.

2017 оны 1 сард Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захирлаар Д.Далайжаргалыг томилсон байна.

“Мон-Атом” ХХК нь улсын төсвөөс санхүүжилт авдаггүй, одоогоор орлогын эх үүсвэргүй бөгөөд ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт хийж байгаа гадны компаниас авсан зээлийн эх үүсвэр болон “Эрдэнэс Монгол” ХХК-аас авсан зээлээр 2016 оны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн ажиллаж байна.

2016 онд Төлөөлөн удирдах зөвлөл болон Төрийн өмчийн хороо, Төрийн өмчийг хариуцсан байгууллагаас зорилтот түвшин, орлого зардлын хязгаарыг баталж өгөөгүй учраас ашигт ажиллагааны түвшин үр дүнг үнэлэх боломжгүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Мон-Атом ХХК нь Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн Энергийн тухай хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацраг идэвхит ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, тандан судалгаа, хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийг тогтоох, тэдгээрийг олборлох, ашиглах, цөмийн түлш, эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, тэдгээрт шаардлагатай материаллаг бааз болон үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, энэ салбар дахь

гадны болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүдэд төрийн өмчийн оролцоог хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн зорилготой.

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.”, мөн хуулийн 5.5 дугаар зүйлд “Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэж заасныг үйл ажиллагаанд мөрдөж байна.

Дээр дурьдсан зорилгын хүрээнд “Төв Азийн Уран” ХХК, “Гурвансайхан” ХХК, “Мон-Чех Ураниум” ХХК хамтарсан компанид хувь эзэмшиж байна.

“Мон-Атом” ХХК-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Мон-Атом” ХХК-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Мон-Атом” ХХК нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан

бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй хэдий ч тус байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж бий болсон хайгуул үнэлгээний хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт данстай холбогдсон нарийн төвөгтэй ажил гүйлгээнүүдийг бүртгэх горимыг тусгаагүй байна.

“Мон-Атом” ХХК-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Мон-Атом” ХХК нь тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулж санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч сүүлийн хагас жилийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн журнал, дэлгэрэнгүй тайлан, ажил гүйлгээний товчоог бидэнд ирүүлээгүй бөгөөд санхүүгийн тайланг хэрхэн бэлтгэн гарсныг тодорхойлох боломжгүй байна.

Материаллагийн түвшин:

Аудитын материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс 2 хувиар 55,124.1 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллагийн суурийг өөрчлөөгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Мон-Атом” ХХК-ын байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын эрсдэл өндөр байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Мон-Атом” ХХК нь 2016 онд үйл ажиллагааны орлого олоогүй бөгөөд үйл ажиллагаанаас 1,509,538.7 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Төрийн өмчийн хорооноос үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,957.1 мянган төгрөгийн хөрөнгө, дутагдсан хөрөнгийг ажилтан албан хаагчдаас суутган тооцсон 2,230.5 мянган төгрөгийг хөрөнгө борлуулсны олзоор тус тус бүртгэсэн байна. Орлогын дэлгэрэнгүй тайланд ерөнхий удирдлага борлуулалтын зардал 548,489.9 мянган

төгрөг, валютын ханшийн бодит бус алдагдал 965,406.9 мянган төгрөг гэж тайлагнасан байна.

“Мон-Атом” ХХК-ийн ТУЗ болон Төрийн өмч хариуцсан байгууллагаас 2016 оны зорилтот түвшнийг батлаагүй байна. Иймээс аудиторын зүгээс компанийн орлого, зардал, ашгийн үзүүлэлтийг зорилтот түвшинтэй зэрэгцүүлж, үр ашгийн талаар тайлбар өгөх боломжгүй байна.

Шилэн дансны мэдээлэл

“Мон-Атом” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг байршуулж эхэлсэн. Гэвч 2016 оны зорилтот түвшин, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, санхүүгийн тайлан (*Бүтэн жилээр, Хагас жилээр*), санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тушаал шийдвэр зэрэг мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 чиглэлийн дансад хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал:

- Хайгуул үнэлгээний хөрөнгөөр бүртгэгдсэн тандан судалгааны ажлын 1,927,177.2 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн оршин байх, хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нэмэгдсэн өртөгийн албан татварын илүү төлөлтийн 96,349.0 мянган төгрөгийн авлага, “Мон Зим Интернэшнл” ХХК-д төлөх 109,000 ам доллар буюу 216,065.3 мянган төгрөгийн өр төлбөрийг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна
- Монгол, БНЧУ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай “Мон-Чех Ураниум” ХХК байгуулагдсан үед тус компанид “Ураниум Индастри” ХК-иас оруулсан хөрөнгө оруулалтад тооцогдох 2 сая ам.долларыг “Мон-Атом” ХХК нь “Ураниум Индастри” ХК-д өгөх өр төлбөрөөр бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- “Төв Азийн Уран” ХХК-ийн нийт хувьцааны Монголын төрийн эзэмшлийн 21 хувийн төрийн төллөөлөл болох 755,928.1 мянган төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалт нотлогдохгүй байгаа нь

санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- “Ураниум Индастри” ХК-тай 2015 онд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Мон-Чех Ураниум” хамтарсан компанид “Мон-Атом” ХХК-иас оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэх ёстой 51.0 мянган ам.долларыг хөрөнгө оруулалт, өр төлбөрөөр бүртгэж толилуулаагүй нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Мон-Атом” ХХК-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, цалин зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн журнал, дэлгэрэнгүй тайлан, ерөнхий дансыг бүрэн гүйцэд хөтлөөгүй, аудит хийхэд шаардлага хангахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн журнал дансыг бидэнд ирүүлээгүй учраас тайлант жилд гарсан онцлог ажил гүйлгээг бусад баримтыг үндэслэн тогтоовол:

- Компанид бүтцийн өөрчлөлт хийгдэж 2016 оны 5 сарын 31-ээр тасалбар болгож 1 сарын тэтгэмжтэйгээр бүх ажиллагсдыг ажлаас чөлөөлснөөр 39,950.0 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн.
- Тайлант онд валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж урт хугацаат өр төлбөр 1,061,132.5 мянган төгрөгөөр нэмэгдэж 5,352,489,5 мянган төгрөг болсон.
- Тайлант онд өмнөх онуудад хуримтлагдсан цалин, НДШ, ХХОАТ-ын өр төлбөрийг барагдуулаагүй бөгөөд 2016 онд орлого хөрөнгийн эх үүсвэргүй байдлаас шалтгаалан дээр өр төлбөр 365,487.3 мянган төгрөгөөр өсөж, цалин, түүнтэй холбоотой өр төлбөр 949,282.8 мянган төгрөгт хүрсэн.
- Тайлант онд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхийн тулд “Эрдэнэс таван толгой” ХХК-аас 30,000.0 мянган төгрөг, “Эрдэнэс Монгол” ХХК-аас 155,100.0 мянган төгрөгийн зээл авсан байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа гарсныг шийдвэрлэсэн байдлыг тэмдэглэвэл:

- ❖ 2016 оны санхүүгийн тайлангийн эхний болон эцсийн үлдэгдэлд тусгагдсан 1,927,177.2 мянган төгрөгийн хайгуул үнэлгээний хөрөнгө нь бодитойгоор оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй. Хөрөнгө оршин байгааг нотлох хангалттай, зохистой нотолгоо байхгүй. Бодитой оршин байгаа эсэхийг судлахад хайгуул, үнэлгээний хөрөнгөд бүртгэгдсэн 1,927,177.2 мянган төгрөг нь 5 орд газар дээр тандан судалгаа хийхэд зарцуулагджээ. Эрэл тандан судалгааны ажлаар тогтоосон тухайн хүдэржилтийн бүсэд байгаа цацрагт идэвхт бодисын нөөцийг бүртгэсэн тухай АМГ-ын шийдвэрийг бидэнд өгөөгүй. Өөрөөр хэлбэл тандан судалгаа хийсэн зардлыг хайгуул үнэлгээний хөрөнгөөр бүртгэсэн байна. Энэ нь СТОУС 6 *Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ*, Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар батлагдсан *"Ашигт Малтмалын Хайгуулын болон Ашиглалтын Зардлыг НББ-д Бүртгэх журам"*-ыг зөрчсөн байна.
- ❖ “Төв Азийн Уран” ХХК-д холбогдох 755,928.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт нотлогдохгүй байна. Тус хамтарсан компанийн компанийн эзэмшиж байсан лицензийг цуцалснаар Канадын талд хөрөнгө оруулалтаа татаж, Монголын Засгийн газар нөхөн төлбөр төлөхөөр шийдвэрлэгдсэн. Энэхүү шийдвэртэй холбоотойгоор “Төв Азийн Уран” ХХК татан буугдсан эсэх нь тодорхойгүй, санхүүгийн тайланд хөрөнгө оруулалттай холбоотой тохируулах бичилт, санхүүгийн тайлангийн толилуулга тодруулга хийгдээгүй байна. Түүнчлэн бидэнд байгаа мэдээллээр Төв Азийн Уран ХХК-аас хайгуул үнэлгээний ажил хийгдэж байсан орд газарт хамаарах хайгуул үнэлгээний тайлан, ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, тайлан судалгааны ажлыг хүлээн авсан эсэх, хэрхэн үнэлж бүртгэх нь тодорхойгүй байна.
Холбогдох баримт бичгүүдийг өгөөгүй учраас “Төв Азийн Уран” ХХК-д оруулсан хөрөнгийн оруулалттай холбоотойгоор үүсч болзошгүй үүрэг хариуцлага, хөрөнгийн үр нөлөө, санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн оруулалтын үнэн зөв байдлыг тодорхойлох боломжгүй байна.
- ❖ Тайлант онд тодорхой зорилгогүйгээр 2 арилжааны банкинд 5 харилцах данс нээсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 158,2 мянган төгрөг гэж санхүүгийн тайланд толилуулсан байна. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг бидэнд ирүүлсэн баримтанд тулгуурлан тооцвол 771.2 мянган төгрөг байхаар байна. Харилцагч банкинд тулган баталгаажуулах захидал

илгээсэн боловч хариу ирүүлээгүй учир мөнгөн хөрөнгийн үнэн зөв бүртгэж толилуулсныг нотолж чадсангүй.

- ❖ 2016 оны бэлэн мөнгөний зарцуулалтыг анхан шатны баримт болон дэмжих баримт руу тулган шалгахад нийт 49,270.8 мянган төгрөгийн ажил гүйлгээ нь нотлох дэмжих баримт дутуу, зөвшөөрсөн, хүлээн авсан гарын үсэг дутуу, мөнгөн зарлага, бэлэн мөнгө олгохыг хүссэн баримтгүй байна. "Мон-Атом" ХХК-ийн санхүүгийн баримтыг үзэж шалгах явцад компанийн үйл ажиллагаатай хамааралтай байж болох 15,835.8 мянган төгрөгийн ажил гүйлгээний баримт байна. Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй учраас тулган шалгах боломжгүй байгаа бөгөөд дээрх баримтанд мөнгийг хүлээн авсан тухай тэмдэглэсэн байх боловч ямар эх үүсвэрээс хэн олгосон болох нь тодорхойгүй, кассын тайланд ч байхгүй байна. Иймд санхүүгийн тайлан 65,106.6 мянган төгрөгийн алдаатай илэрхийлэгдсэн байх магадлалтай байна.

Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дугаар зүйлд заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". заалтыг зөрчсөн байна.

- ❖ "Мон-Атом" ХХК нь 2012 оны 11 дүгээр сарын 16-нд Бүгд Найрамдах Чех улсын "Ураниум Индастри" ХК-тай "Монгол улсад Цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, тандан судалгаа, геологи хайгуул, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах гэрээ" байгуулсан байна. Хамтын ажиллагааны эхний үе шатны 25,000мкв талбайд эрэл, тандан судалгаа хийх гэрээт ажлын санхүүжилт нь 2,000.0 мянган доллар байхаар заасан байна. Санхүүгийн тайланд гэрээний дагуу 2012-2013 онд хүлээн авсан 2,000.0 мянган долларын санхүүжилтийг урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэж, толилуулсан байна.

"Мон-Атом" ХХК -ийн гүйцэтгэх захирал асан Ж.Билэгсайхан нь 2013 оны 12 дугаар сарын 25-нд "Увс, Ховд, Баян Өлгий аймгуудын нутаг дэвсгэрт 29820мкв талбайд сансрын геологи, цөмийн механик соронзон резонансын тандан судалгааны "Поиск" цогц төхөөрөмжийг ашиглан ураны хүдэржилтийг тогтоосон эрэл-үнэлгээ, эрэл- хайгуулын ажлын тайлан болох 2 боть материалыг Монгол, Англи хэлээр тус бүр 1%-ийг "Ураниум Индастри" ХК-ийн Удирдах зөвлөлийн дарга Милан Клечка-д хүлээлгэн өгсөн байна. Хэрэв "Ураниум Индастри" ХК-тай байгуулсан гэрээний үр дүнг дүгнэсэн акт, протокол, "Мон-Атом" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарвал "Хувьцаа эзэмшигчдийн гэрээний Ерөнхий зүйлийн D хэсэгт: Баруун-1 талбайд эрэл, үнэлгээний ажил хийхээр "Мон-Атом" ХХК-д компанид төлсөн төлбөрийг хамтарсан компанид "Ураниум Индастри" компанийн оруулсан хөрөнгө оруулалтанд тооцно" гэж заасныг үндэслэн 2,000.0 мянган долларын урт хугацаат өр төлбөрийг хааж, "Ураниум Индастри" ХК-иас "Мон-Чех Ураниум" ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтад шилжүүлэхээр байна.

Дээрх өр төлбөрт бүртгэсэн 2,000.0 мянган долларын ажлын үр дүнг хэрхэн үнэлж, гэрээний үүргийг хангалттай гүйцэтгэсэн тухай, эрэл, тандан судалгааны ажлын үр дүнг хамтарсан компани руу шилжүүлэх тухай "Ураниум Индастри" компанитай хэлэлцсэн протокол болон "Мон-Атом" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг бидэнд ирүүлээгүй.

Энэхүү тодорхой бус байдлаас шалтгаалан 2,000.0 мянган ам долларыг "Ураниум Индастри" ХК-иас оруулж буй хөрөнгө оруулалт гэж бүртгэх эсэх, эсвэл эрэл хайгуул тандан судалгааны ажлын орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэх эсэх, холбоотойгоор "Мон-Атом" ХХК-ийн хүлээх эрсдэл, үүрэг хариуцлага нь санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлж чадсангүй.

- ❖ "Ураниум Индастри" ХК-тай 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу "Мон-Чех Ураниум" хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэх ёстой 51.0 мянган ам.доллар бүртгэгдээгүй байна. Мөн "Ураниум Индастри" ХК-иас 51.0 мянган ам.доллар "Мон-Чех Ураниум" хамтарсан компанийн данс руу гэрээнд заасан хугацаанд орсон эсэхийг баталгаажуулаагүй. Гэрээнд заасны дагуу "Мон-Атом" ХХК-ийн анхны хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр болох 51.0 мянган ам.доллар (101,086.6 мянган төгрөг)-ыг өр төлбөр, Хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгээгүй байна. Энэ Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг зөрчиж урт хугацаат хөрөнгө оруулалтын төрөл, дүн, бий болсон буюу бий болох олз гарз, үүрэг, хариуцлагын талаар тодруулагдаагүй байна.
- ❖ 2015 онд "Ураниум Индастри" ХК-тай байгуулсан зээлийн гэрээнд заасны дагуу хүүг тооцож /тооцоо нийлсэн актаар тодорхойлж, баталгаажуулах/ санхүүгийн тайланд өр төлбөр, хүүгийн зардлаар (жилийн хүү LIBOR + Дэнчин) толилуулж, тодруулаагүй байна. СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.46 өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, 4.49 зардлын хүлээн зөвшөөрөлтийг зөрчсөн, мөн Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг зөрчиж тайлант хугацаанд хамаарах хүүгийн өр төлбөр, хүүгийн зардлыг толилуулж, тодруулаагүй байна.
- ❖ Тайлант онд орлого олоогүй, зорилтот түвшин, зардлын хязгаарыг баталж өгөөгүй байхад хандив, бэлэг, баяр ёслол тэмдэглэн өнгөрүүлэхэд 13,905.8 мянган төгрөгийг зарцуулж, зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1-р зүйлд "Төрийн

өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний саналыг тусган, хуулийн этгээдийн удирдлагатай 3 дугаар сарын 25-ны дотор тохиролцоно" гэсэн заалтыг зөрчиж 2016 оны зорилтын саналаа батлуулаагүй байна. Иймээс аудиторын зүгээс компанийн орлого, зардал, ашгийн үзүүлэлтийг зорилтот түвшинтэй зэрэгцүүлж, дүгнэх боломжгүй байна.

- ❖ Тайлант онд цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээр 376,225.2 мянган төгрөгийн олговол зохих цалин тооцоолсон боловч Нийгмийн даатгалын байгууллагад 405,355.0 мянган төгрөгийн олговол зохих цалингаас, НДШимтгэлийг суутган тооцсон тайланг илгээсэн байна. Нийгмийн даатгалын тайлангаар илүү тооцоолсон 29,129.8 мянган төгрөгийн цалингийн зөрүү нь шүүхийн шийдвэрийн дагуу нэмж олгох цалингаас 23,081.7 төгрөг, 11 сард холбогдох баримт, шийдвэргүйгээр Д.Ганхуягт олгохоор тооцсон цалингаас 1,920.0 мянган төгрөг, Б. Мөнхбаярын тооцоолсон цалингийн зөрүүгээс 450.0 мянган төгрөг, Л.Ганбаатарт 12 сард цалин олгохоор тооцоолоогүй боловч Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан 2,704.8 мянган төгрөг, 10.11 сарын цалинг тооцоолсон цалингаас дутуу дүнгээр Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан 913.5 мянган төгрөгөөр тус тус зөрж байна. Түүнчлэн татварын байгууллагад ХХОАТ суутган тооцох орлогыг 3,528.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. 2016 оны ихэнх сарын цагийн бүртгэл байхгүй, компанийн бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаагаас томилсон, чөлөөлсөн, цалинг тогтоосон тушаал шийдвэр дутуу, 2016 оны 7 сараас хойш нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй зэргээс хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийн дагуу олговол зохих цалинг бүрэн хэмжээнд тооцоолох боломжгүй байгаа нь цалингийн өглөг, НДШ, ХХОАТ-ын тооцооллыг үнэн зөв хийсэн гэдгийг нотлох баримтыг олж авч чадсангүй. Иймд санхүүгийн байдлын тайланд толилуулагдсан НДШ, ХХОАТ, цалингийн өглөг, орлогын тайланд тусгагдсан цалин, НДШ-ийн зардал нь бүхэлдээ алдаа илэрхийлэгдсэн байх магадлалтай байна.
- ❖ Тайлант онд 2016 оны 8 сараас хойш НӨАТ-ын тайланг гаргаж, татварын байгууллагад илгээгээгүй, татварын тооцож нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнээс шалтгаалан 346,752.31 төгрөгийн НӨАТ-ын худалдан авалтын буцаалтыг тайлагнагдаагүй байна. НӨАТ -ын тухай хуулийн 16.1-д "албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа ажил үйлчилгээнд ногдох татварыг дараа сарын 10-ны дотор баталсан маягтын дагуу харъяалах татварын албанд тушаана" гэсэн заалтыг зөрчсөн нь Татварын ерөний хуулийн 75.1.3-т заасны дагуу үүрэг хариуцлага хүлээхээр байна.

- ❖ “Мон-Атом” ХХК нь тайлант онд 1,509,538.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Гадаад валютын ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор санхүүгийн тайлан, татварын тайлан хооронд үүсч буй түр зөрүүг тооцож, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр дансанд бичилт хийгээгүй байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

“Мон-Атом” ХХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд илэрсэн алдаанууд нь санхүүгийн тайланд тархмал хэлбэртэй, ажил гүйлгээг засаж залруулахад холбогдох баримтуудыг бүрдүүлэх, тооцоо нийлж баталгаажуулах шаардлагатай бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг дахин давтан гүйцэтгэх шаардлагатай байх тул цаг хугацааны давчуу байдлаас шалтгаалан залруулагдах боломжгүй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Мон-Атом” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт дутмаг, тодорхой бус байгаагаас тус компанийн үндсэн үйл ажиллагааны зардлыг гадаад, дотоодын компаниудаас зээл авч нөхөж байна. Иймд тус компани хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орлого, санхүүжилтийн асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

Хамтарсан компанид БНЧУ-ын “Ураниум Индастри” ХК-иас хөрөнгө оруулалт хийх зорилгоор “Мон-Атом” ХХК руу шилжүүлсэн 2 сая ам.долларыг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй, мөн “Мон-Атом” ХХК-иас хамтарсан компанийн дүрмийн санд оруулах анхны хөрөнгө оруулалт 51.0 мянган ам.долларыг “Ураниум Индастри” ХК-иас зээлийн гэрээгээр авахаар тохиролцсон боловч гүйцэтгэлийг нь баталгаажуулж, данс бүртгэлд тусгаагүй, “Төв Азийн Уран” ХХК-ийн төрийн төлөөллийн эзэмшлийн хувь, хөрөнгийн дүн тодорхойгүй байгаа зэрэг асуудлуудтай холбоотойгоор өр төлбөр нэмж үүсэх эрсдэл өндөр байна.

Эдгээрээс шалтгаалж зээлийн үндсэн төлбөр, түүний хүү, торгуулийн төлбөр нэмэгдэж, компани цаашилбал Монгол Улсын Засгийн газрын өр төлбөр нэмэгдэхэд хүргэж болзошгүй.

Түүнчлэн “Мон-Чех Ураниум” хамтарсан компанид Монголын талаас орд газар буюу лицензээр оруулсан хөрөнгө оруулалтыг хэрхэн бүртгэсэн, 2013 оноос 15%-ийг нь эзэмших болсон “Гурвансайхан” ХХК болон гэрээ хэлэлцээрийн шатанд байгаа хамтарсан компанийн хөрөнгө оруулалт хэрхэн яаж бүртгэгдсэн, дээрх компаниуд ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа, хэрхэн хяналтыг хэрэгжүүлж байгаа тодруулж шалгах шаардлагатай. Аудитын явцад “Мон-

Атом”ХХК нь хамтарсан компанид Засгийн газрын төлөөлөх эрхийг хэрхэн хэрэгжүүлж тайлагнасныг үнэлээгүй болно.

Ажлаас халагдсан боловч цалингаа аваагүй, НДШ төлөгдөөгүйгээс Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж, хөнгөлөлтийн үйлчилгээ авч чадахгүй байгаа хүмүүс шүүхэд зарга маргаан үүсгэсэн бөгөөд хүү алдангиар өр төлбөр нэмэгдэж болзошгүй байна.

Түүнчлэн тайлант онд гүйцэтгэх захиралын гаргасан тушаал шийдвэр, зарга маргаантай асуудалд өгсөн тайлбарын хувьд компани төлөөлөх, шийдвэр гаргах эрх, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах, хэрэгжих боломжтой эсэх, гаргасан шийдвэрийн үр дагаврыг тодорхойлох шаардлагатай байна. Тухайлбал: гүйцэтгэх захирал Л.Ганбаатар нь 2016/11/03 -ны өдрийн 018/08 тоот тушаал гаргаж, 2016 оны 7 дугаар сарын 1-ээс өмнө ажиллаж байсан албан хаагчдын цалингийн алдангийг Хөдөлмөрийн хуулийн хязгаарт багтаан хүлээн зөвшөөрч, олгох тухай тушаал гаргасан байна. Хөдөлмөрийн хуулийн 141.4-т зааснаар цалинг саатуулсан алдангийг шүүх ажил олгогчид ногдуулж, ажилтан олгохоор заасан байна. Иймд дээрх тушаал нь эрх зүйн хувьд үндэслэлтэй эсэхийг дахин тогтоох шаардлагатай.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Мон-Атом” ХХК-ын 2016 оны санхүүгийн тайлан бүхэлдээ алдаа илэрхийлэгдсэн, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн ажилтнууд тайланд онд бүрэн солигдсоноос дотоод хяналт бүхэлдээ алдагдаж, үйл ажиллагаа, хөрөнгө, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөнд тавих хяналт алдагдсан байна.

Аудитаар илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудлуудын нөлөөлөл, үр дагаврыг нарийвчлан тогтоох, “Мон-Атом” ХХК болон Монгол Улсын Засгийн газарт учирч болзошгүй эрсдлийг бууруулах зорилгоор гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай байна.

Хамтарсан болон хөрөнгө оруулалт хийсэн компанийн үйл явц, хөрөнгийн үр өгөөжид гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай.

Хөрөнгө оруулалт хийсэн компанид хяналтаа хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлж чадаагүй учраас “Мон-Атом”ХХК нь Сангийн сайдын 2015 оны 170 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх эсэхийг үнэлж чадаагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Мон-Атом” ХХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 8,632,289,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Мон-Атом” ХХК нь 2013-2015 онуудын санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Өмнөх оны аудитаар менежментийн захидлаар өгсөн 8 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд дээрх зөрчлүүд дахин давтагдаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Дараах асуудлуудаас шалтгаалж олон тооны тодорхой бус байдал бүрт харгалзах аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авч чадаагүй бөгөөд уг тодорхой бус байдлуудын үр дагавар ба санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөг тодорхойлох боломжгүй байна.

- Нэмэгдсэн өртөгийн албан татварын илүү төлөлтийн 96,3 сая төгрөгийн авлага, “Мон Зим Интернэшнл” ХХК-д төлөх 109,000 ам доллар буюу 216.1 сая төгрөгийн өр төлбөрийг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа нь,
- 2013 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээний дагуу “Ураниум индастри” ХК-аас авсан 2,000.0 мянган доллар буюу 4,917.0 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр, 1,927.5 сая төгрөгийн эрэл хайгуул, тандан судалгааны ажлын төлбөрийг биет бус /хайгуул үнэлгээний/ хөрөнгө гэж бүртгэж тайлагнасан нь СТОУС-ын холбогдох шаардлагад нийцээгүй байх бөгөөд холбогдох баримт бичиг, шийдвэр дутуу байгаагаас дээрх дүнг залруулах, эсвэл данснаас хасахтай холбоотой санхүүгийн тайланд нөлөөлөх үр дагаврыг тооцох боломжгүй байгаа нь
- 2015 онд зээлийн гэрээний дагуу “Ураниум индастри” ХК-аас валютаар авсан 150,000 ам доллар, бэлэн бусаар тооцсон 51,000 ам доллар, нийт 201,000 ам долларын зээлийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагыг толилуулж тодруулаагүй,
- “Мон-Чех Ураниум” хамтарсан компанид зээлийн эх үүсвэрээр оруулсан 51,000 ам долларыг хөрөнгө оруулалтаар бүртгээгүй,
- Санхүүгийн байдлын тайланд илэрхийлсэн “Төв азийн уран” ХХК оруулсан 755,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн байдлын тайланд бүртгэж толилуулаагүй “Мон-Чех Ураниум” ХХК-д оруулсан байвал зохих

51,000 ам доллар буюу 127,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь үнэн зөв толилуулагдсан эсэх, хамтран хянадаг дээрхи компанийн хөрөнгөөс тус компанийн эзэмших хувь хэмжээ бодитой эсэхийг нотлох хангалттай бөгөөд зохистой нотолгоо олдоогүй, өмнөх аудитаар энэхүү асуудал илэрч аудиторын дүгнэлтийн хязгаарлалтын нөхцөл болсон бөгөөд бидний өгсөн зөвлөмжийн дагуу тус компанийн удирдлагаас хөрөнгө оруулалтыг баталгаажуулах талаар удирдлагаас хариу арга хэмжээ аваагүй өнөөг хүрсэн нь,

- Мөнгөн хөрөнгийг 0,6 сая төгрөгийн зөрүүтэйгээр санхүүгийн тайланд бүртгэж толилуулсан нь,
- Анхан шатны баримт болон дэмжих баримтын зөрчилтэй 49.3 сая төгрөгийн, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайланд тусгагдаагүй байх магадлалтай 15.8 сая төгрөгийн санхүүгийн баримт, цалин, НДШ, ХХОАТ тооцолт, тайлагналаас 12.4 сая төгрөгийн зөрчил гарсан нь,
- Тайлант онд орлого олоогүй, зорилтот түвшин, зардлын хязгаарыг баталж өгөөгүй байхад хандив, бэлэг, баяр ёслол тэмдэглэн өнгөрүүлэхэд 14.0 сая төгрөгийг зарцуулж, зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1-р зүйлд заасныг зөрчиж 2016 оны зорилтын саналаа батлуулаагүй байгаа нь,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртөгийн албан татварыг зохих ёсоор тайлагнаагүй нь,
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч холбогдох нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн журнал, тайлан, дэлгэрэнгүй бүртгэлийг зохих ёсоор бүрэн гүйцэд хөтлөөгүй нь

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, СТОУС 6 “Ашигт малтмалын хайгуул ба үнэлгээ”, СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.46 өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, 4.49 зардлын хүлээн зөвшөөрөлтийг тус тус зөрчиж, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Татгалзсан санал дүгнэлт

Татгалзсан дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлийн ач холбогдлоос шалтгаалан бид аудитын дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй бөгөөд алдаа зөрчил нь санхүүгийн тайланд тархмал бөгөөд өндөр дүнгээр нөлөөлөхөөр байсан. Иймээс, бид “Мон-Атом” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.